

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ
ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

2025.12.19

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн, хүрсэн түвшинг тодорхойлох, цаашид бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, ил тод байдлыг хангахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт, хүрсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг үндэслэл болгов.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1,6.3,6.4-д заасан аргачлалыг удирдлага болгов.

Хоёр. Хяналт-шинжилгээний үр дүн

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор “**Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл**”-ийн 1.3.2.7. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит компани болон компанийн нэгдэл хэлбэрээр ажилладаг төрийн өмчит компанийн үйл ажиллагааг уялдуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай зарим компанийг олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ, “**Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө**”-ний 1.1.2.1.Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд үе шаттай, нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх, “**Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт**”-ийн 1.1.2. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна гэж тус тус батлагдсан.

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”:

д/д	Тэргүүлэх чиглэл	Зорилго	Зорилт
Нэг. Эдийн засгийн бодлого			
1.	1.3. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна.	1.3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд:	1.3.2.7. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, төрийн болон орон нутгийн өмчит компани болон компанийн нэгдэл хэлбэрээр ажилладаг төрийн өмчит компанийн үйл ажиллагааг уялдуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай зарим компанийг олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.

Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”:

д/ д	ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөр ийн үр дүн	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт	
						Суурь түвшин /2023 он/	Зорилтот түвшин /2025 он/	сая. төг	Эх үүсвэрийн ангилал
Нэг. Эдийн засгийн бодлого									
1.	1.1.Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	1.1.2. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна.	1.1.2.1.Төри йн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд үе шаттай, нээлттэй худалдах арга хэмжээг хэрэгжүүлэх	Олон нийтийн хяналтад оруулах төрийн өмчит компани	тоо	2	5	100.0	Улсын төсөв

Гурав. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”:

д/д	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин
Хөтөлбөрийн үр дүн						
1.1.2	Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна.	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж /ROA/, <u>хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь</u>	хувь	2023	3.5	<u>77-?</u> (4.0)

1. “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл” – **90.0 хувь буюу “Үр дүнтэй”** дүгнэгдсэн.

Үр дүн:

- Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээд, үйлдвэрийн газруудын өмчлөлийн хэлбэр, засаглалыг сайжруулах загвар төслийн хүрээнд компанийн засаглалын талаарх олон улсын

сайн туршлагыг Монгол улсын өнөөгийн нийгэм эдийн засгийн онцлогт нийцүүлэх байдлаар боловсруулсан;

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан төрийн өмчит компаниудад бүтцийн өөрчлөлт хийх, өөрчлөн зохион байгуулах, чиг үүргийн давхардлыг арилгах, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах асуудлыг судалж, салбарын яамтай хамтран дараах компани, үйлдвэрийн газруудыг нэгтгэх, татан буулгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үүнд:
 - “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д нэгтгэх;
 - “Богдын голын усан цахилгаан станц” ХХК, “Тосонцэнгэлийн усан цахилгаан станц” ХХК, “Тайшир-Гуулингийн усан цахилгаан станц” ХХК-ийг нэгтгэх;
 - Алтай-Улиастай Завхан салбар болон бусад түгээх сүлжээний салбаруудыг нийлүүлж, “Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК болгох;
 - “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ыг “Эрчис Ойл” ХХК-д нэгтгэх;
 - “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨААТҮГ-ыг “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” ТӨААТҮГ-т нэгтгэн зохион байгуулах;
 - “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д нэгтгэн зохион байгуулах;
 - “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ыг татан буулгах.
- Засгийн газрын 2025 оны “Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 285 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг үе шаттай авч байна. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хуралдаанаар хэлэлцээд УИХ-д өргөн барихаар тогтсон “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн төсөлд “Эрдэнэс Монгол” ХХК-ийг олон улсын менежментийн багаар удирдуулах асуудлыг тусгасан болно.

2. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” – 70 хувиар дүгнэгдсэн.

Үр дүн:

- “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хуралдаанаар хэлэлцээд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган, “Шинэ итгэл-Эрс шинэтгэл” “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д нийцүүлэн дахин боловсруулахаар 30.4 дүгээр тэмдэглэлд тусган шийдвэрлэсэн. “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй

худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг дахин боловсруулж, 18 хуулийн этгээдэд IPO хийх, 8 этгээдийн төрийн мэдлийн хувьцааг худалдах, 7 хуулийн этгээдэд бүтцийн өөрчлөлт хийх саналыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газраас УИХ-д уг үндсэн чиглэлийг батлах тогтоолын төслийг өргөн барихаар тогтсон.

3. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт” – **100.0 хувь буюу “үр дүнтэй”**.

Үр дүн:

- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 67 хуулийн этгээдийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар баталгаажсан тайлангийн дүнгээр тооцоход хөрөнгийн өгөөж 9.64 хувь байна. (2025 оны ROA нь 2026 онд гарна.)

Гурав. Дүгнэлт

“Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д 1 зорилт, 1 арга хэмжээ (1.3.2.7.), “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-д 1 зорилт, 1 арга хэмжээ (1.1.2.1.), “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийн хөтөлбөрийн үр дүнд 1 үр дүн (1.1.2) тус тус тусгагдсан.

1.1.2.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд үе шаттай нээлттэй худалдах арга хэмжээ нь хуульд шаардлагатай өөрчлөлт, холбогдох хуулийн шинэчлэлийг хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгосны дараа үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх боломжтой болно.

Тайлант хугацаанд холбогдох хуулиудын төслүүд боловсруулагдаж (Нийтийн өмчийн хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төсөл), УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэн дэмжигдэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн Засгийн Байнгын хороонд шилжүүлсэн байна.


Хэдийгээр 1.1.2.1 – ийн зорилтот түвшинг бүрэн хангаагүй ч уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг дахин боловсруулж, 18 хуулийн этгээдэд IPO хийх, 8 этгээдийн төрийн мэдлийн хувьцааг худалдах, 7 хуулийн этгээдэд бүтцийн өөрчлөлт хийх саналыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газраас УИХ-д уг үндсэн чиглэлийг батлах тогтоолын төслийг өргөн барихаар тогтсон үр дүнтэй байсан учраас тухайн арга хэмжээг 70 хувиар дүгнэсэн болно.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийн шалгуур үзүүлэлтийн **хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, зорилтот түвшин 77** гэсэн үзүүлэлт нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өгсөн санал биш учир Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж /ROA/-өөр гүйцэтгэлийг тайлагнасан болно.

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Тайлангийн хэрэгжилтийг зөвхөн 2000 тэмдэгтэд багтаан гарсан үр дүнг тайлагнаж байх;
- Үр дүн гараагүй зорилт, арга хэмжээний шалтгааныг тайлбарын хамт ирүүлэх.


Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСЭЙН
ДАРГА  Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН  Д.ЦЭРЭНЛХАМ